



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө хүлээн авах,
бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сүхбаатар аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан, нийт 25,990,000.00 (хорин таван сая есөн зуун ерэн мянган) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шинжилгээний албанд эзэмшүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал, Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Алтансүх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;


2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн
139 дугаар тогтоолын хавсралт

СҮХБААТАР АЙМГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ,
ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
АЛБАНД ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр, марк | Ашиглалтад орсон он | Тоо хэмжээ | Балансын нийт үнэ (төгрөг) |
|-----|---------------------------------------|---------------------|------------|--|
| 1 | Микротом /эргэлтэт, biobase/ | 2019 | 1 | 12,800,000.00 |
| 2 | Парафан цутгагч, biobase | 2019 | 1 | 1,470,000.00 |
| 3 | Микроскоп /гэрлийн/ biobase | 2019 | 1 | 1,200,000.00 |
| 4 | Эдийн усгүйжүүлэх дамжлагын төхөөрөмж | 2019 | 1 | 8,120,000.00 |
| 5 | Шилэн бэлдэц хадгалах шүүгээ, biobase | 2019 | 1 | 1,200,000.00 |
| 6 | Термостат, biobase | 2019 | 1 | 1,200,000.00 |
| | Нийт дүн | | | 25,990,000.00 (хорин таван сая есөн зуун ерэн мянган) |